

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**МЯНГАН УГАЛЗАТ ОНӨААТҮГ-ын 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/2/СТА-ОНӨААН

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: BoldbaatarKh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsurena@audit.gov.mn Аудитор: Ц.Аззаяа Утас: 70432545 цахим хаяг: Azzaya.Ts@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

<b>АДБОУС</b>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<b>АОУС</b>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<b>УСНББОУС</b>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<b>ТТЗ</b>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<b>ТШЗ</b>	<i>Төсвийн шууд захирагч</i>
<b>НББББ</b>	<i>Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг</i>
<b>ЗДТГ</b>	<i>Засаг даргын дамгын газар</i>
<b>ОНХС</b>	<i>Орон нутгийн хөгжлийн сан</i>

## Агуулга

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....	5
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	төгрөгөөр .....5
2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН	төгрөгөөр.....6
2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	төгрөгөөр .....7
2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	9
3.АУДИТЫН ТАЙЛАН .....	9
3.1. Ерөнхий зүйл.....	9
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	10
3.4. Материаллаг байдал .....	10
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.7. Шилэн дансны мэдээлэл .....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
3.9. Аудитын илрүүлэлт .....	13
Залруулсан алдаа: Аудитаар залруулсан алдаа байхгүй болно. ....	13
Аудитын зөвлөмж: Аудитаар илэрсэн 1 алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.....	13
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	13
4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	13
<b>Авлга өр төлбөртэй холбоотой асуудал.....</b>	<b>14</b>
5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ .....	14

## 1. ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

МЯНГАН УГАЛЗАТ ОНӨААТҮГ-ЫН  
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Д.ОТГОНТУЯА ТАНАА

2021.03.22 № 2/169  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мянган Угалзат ОНӨААТҮГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Мянган Угалзат ОНӨААТҮГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, ажиллагсдын нийгмийн асуудал зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Аудитын гол асуудал

Мянган Угалзат ОНӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн биелүүлээгүй, өөрийн орлогын төлөвлөгөөг тасалсан, авлага, өр төлбөр үүсгэсэн, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаагүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох эрхзүйн актуудтай нийцэхгүй, аудитын “эрх ба үүрэг”, “үнэн зөв байдал”, “тохиолдсон байх”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

001020736

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>88309803.7</u></b>	<b><u>93058888.9</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	2109725.7	807299.3
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	41393.7	67892.0
31140	Касс арилжааны банк	41393.7	67892.0
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	2068332.0	739407.3
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	2068332.0	739407.3
31213	Арилжааны банк дахь харилцах	2068332.0	739407.3
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	26087802.0	28585950.0
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	26087802.0	28585950.0
3351	Байгууллагаас авах авлага	25837802.0	16269002.0
3352	Хувь хүмүүсээс авах авлага	250000.0	12316948.0
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	60112276.0	63665639.6
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	60112276.0	63665639.6
35470	Бусад хангамжийн материал	60112276.0	63665639.6
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>826252543.8</u></b>	<b><u>800569998.5</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	826252543.8	800569998.5
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	825059113.2	799877480.3
39201	Барилга, байгууламж, орон сууц	576757924.0	364328692.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	-31906629.1	-37568905.4
39203	Авто-тээврийн хэрэгсэл	8000000.0	
39204	Хуримтлагдсан элэгдэл	-8000000.0	
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	80076692.0	348989278.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	-54145050.8	-125455870.8
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	47532433.0	47532433.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	-33288255.9	-37980146.6
39214	Бусад үндсэн хөрөнгө	240032000.0	240032000.0
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	1193430.7	692518.3
39301	Програм хангамж	1500000.0	1500000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-306569.3	-807481.8
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II</b>	<b><u>914562347.5</u></b>	<b><u>893628887.4</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>132854323.0</u></b>	<b><u>162460377.7</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	132854323.0	162460377.7
<b>413</b>	<b>Өглөг</b>	132854323.0	162460377.7
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	132854323.0	162460377.7
41361	Байгууллагад төлөх өглөг	54594049.0	78288684.4
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		1126018.5
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	42035442.6	54396961.9
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/	36224831.3	28648712.8
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>781708024.6</u></b>	<b><u>731168509.7</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	781708024.6	731168509.7
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	599070740.0	599070740.0
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-194444767.5	-176108436.3

51210	Өмнөх үеийн үр дүн	-115561109.0	-194444766.8
51220	Тайлант үеийн үр дүн	-78883658.5	18336330.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	377082052.0	308206206.0
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>914562347.5</u></b>	<b><u>893628887.4</u></b>

## 2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>199,334,321.4</b>	<b>416,789,403.7</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>199,334,321.4</b>	<b>416,789,403.7</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	199,334,321.4	416,789,403.7
120002	Хүүгийн орлого	57,692.9	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	165,899,628.6	147,876,817.7
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	165,899,628.6	147,876,817.7
120009	Бусад орлого	33,377,000.0	268,912,586.0
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>279,354,343.5</b>	<b>267,855,637.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>279,354,343.5</b>	<b>267,855,637.0</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	277,414,343.5	266,057,637.0
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	112,131,166.9	87,565,321.0
210101	Үндсэн цалин	112,131,166.9	87,565,321.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	21,388,094.6	18,777,112.4
210201	Тэтгэврийн даатгал	21,388,094.6	18,777,112.4
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	34,608,534.0	32,029,681.7
210301	Гэрэл, цахилгаан	10,515,572.0	7,400,035.7
210302	Түлш, халаалт	21,891,870.0	21,891,870.0
210303	Цэвэр, бохир ус	2,201,092.0	2,737,776.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,935,075.8	1,905,227.1
210401	Бичиг хэрэг	1,457,672.7	392,500.0
210402	Тээвэр, шатахуун		690,909.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	330,909.1	821,818.0
210404	Ном, хэвлэл	250,000.0	
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	3,896,494.0	
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	47,047,634.8	22,115,579.7

210502	Хоол, хүнс	47,047,634.8	22,115,579.7
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,491,018.2	5,221,850.0
210604	Урсгал засвар	5,491,018.2	5,221,850.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	200,000.0	1,492,300.0
210702	Дотоод албан томилолт	200,000.0	1,492,300.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	11,197,500.0	1,828,716.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,759,500.0	992,196.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.0	784,000.0
210807	Газрын төлбөр	960,000.0	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	78,000.0	52,520.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	39,415,319.2	95,121,849.1
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	39,415,319.2	95,121,849.1
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,940,000.0	1,798,000.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,940,000.0	1,798,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,940,000.0	1,798,000.0
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(80,020,022.1)</b>	<b>148,933,766.8</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	1,136,363.6	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	1,136,363.6	
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	130,597,436.3
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал		130,597,436.3
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	1,136,363.6	(130,597,436.3)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(78,883,658.5)</b>	<b>18,336,330.5</b>

### 2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>235,116,381.4</b>	<b>169,796,470.2</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>235,116,381.4</b>	<b>169,796,470.2</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	235,116,381.4	169,796,470.2
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	213,407,894.0	151,527,200.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	213,407,894.0	151,527,200.0
120009	Бусад орлого	21,255,109.4	18,254,118.2
120015	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө /ТӨҮГ/	453,378.0	15,152.0

<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>235,890,981.2</u></b>	<b><u>171,098,896.9</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>235,890,981.2</b>	<b>171,098,896.9</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>233,497,603.2</b>	<b>171,098,896.9</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	93,339,318.5	74,299,868.9
210101	Үндсэн цалин	93,339,318.5	74,299,868.9
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	4,500,000.0	32,066,709.0
210201	Тэтгэврийн даатгал	4,500,000.0	
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		32,066,709.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	13,828,022.0	9,163,273.0
210301	Гэрэл, цахилгаан	10,515,572.0	7,779,385.0
210303	Цэвэр, бохир ус	1,548,050.0	1,383,888.0
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	1,764,400.0	
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	13,848,674.3	3,754,550.0
210401	Бичиг хэрэг	(224,030.7)	
210402	Тээвэр, шатахуун	2,400,000.0	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	330,000.0	
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	11,342,705.0	3,754,550.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	46,400,000.0	28,915,140.0
210502	Хоол, хүнс	46,400,000.0	28,915,140.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	200,000.0	-
210702	Дотоод албан томилолт	200,000.0	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	61,381,588.3	22,899,356.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.0	
210807	Газрын төлбөр	960,000.0	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	78,000.0	
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	13,757,198.3	4,114,340.0
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	46,186,390.0	18,785,016.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,393,378.0</b>	<b>-</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,393,378.0</b>	<b>-</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	453,378.0	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,940,000.0	
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>(774,599.8)</u></b>	<b><u>(1,302,426.8)</u></b>

<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	<b>1,263,763.1</b>	<b>-</b>
140001	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	1,250,000.0	
140007	Хүлээн авсан хүүний орлого	13,763.1	
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>3,999,700.0</b>	<b>-</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,999,700.0</b>	<b>-</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>3,999,700.0</b>	<b>-</b>
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	2,349,700.0	
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	1,650,000.0	
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(2,735,936.9)</b>	<b>-</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(3,510,536.6)</b>	<b>(1,302,426.8)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>847,045.0</b>	<b>2,109,725.7</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>(2,663,491.6)</b>	<b>807,299.3</b>

## 2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	359,038,740.0	617,114,052.0	-115,561,108.3	860,591,683.7
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>359,038,740.0</b>	<b>617,114,052.0</b>	<b>-115,561,108.3</b>	860,591,683.7
C07	Тайлант үеийн үр дүн			-78,883,658.5	
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>359,038,740.0</b>	<b>617,114,052.0</b>	<b>-194,444,766.8</b>	781,708,024.2
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>599,070,740.0</b>	<b>617,114,052.0</b>	<b>-194,444,766.8</b>	781,708,024.2
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-68,875,846.0		-68,875,846.0
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>599,070,740.0</b>	<b>548,238,206.0</b>	<b>-194,444,766.8</b>	712,832,179.2
D08	Тайлант үеийн үр дүн			18,336,330.5	18,336,330.5
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>599,070,740.0</b>	<b>548,238,206.0</b>	<b>-176,108,436.3</b>	731,168,509.7

## 3. АУДИТЫН ТАЙЛАН

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд Мянган Угалзат ОНӨААТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Отгонтуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл,

анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч өөрийн орлогын төлөвлөгөө, авлага, өр төлбөр, өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилтийн талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 2-ноос 2021 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Аззаяа хариуцаж хэрэгжүүлэв.

### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Мянган Угалзат ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Ажилчдыг аюулгүй орчинд, сэтгэл хангалуун ажиллах, өсөж дэвших боломжоор хангахын зэрэгцээ үйлчлүүлэгчдийн шаардлагад нийцүүлэн, чанартай үйлчилгээ үзүүлэх явдал” гэж тодорхойлсон байна.

- Дээрх зорилго, зорилтын хүрээнд ажилчдынхаа ажлын байрыг бүрэн хадгалж шинэ үйлчилгээ, шинэ ажлын байр бий болгох, аймгийн төдийгүй баруун таван аймгийн хөдөлмөрчид, ахмадууд, хүүхэд залуучуудад соёлтой боловсон, чанартай үйлчилгээ үзүүлэхээр үйл ажиллагаатайгаа уялдуулан ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Мянган Угалзат ОНӨААТҮГ-ын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллага нь өөрийн онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж баталж мөрдөөгүй байна.

Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2020 онд тус байгууллагад дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### **3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зарлагын 279354.3 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 2793.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 441964.4 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 4419.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Мянган Угалзат ОНААТҮГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 20933.4 мянган төгрөгөөр буюу 2.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
Авлага	26087.8	28585.9	2498.1	9.6%
Бараа материал	60112.2	63665.6	3553.3	5.9%
Үндсэн хөрөнгө	826252.5	800569.9	-25682.5	-3.1%
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>914592.3</b>	<b>893628.8</b>	<b>-20933.4</b>	<b>-2.3%</b>
<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>132854.3</b>	<b>162460.3</b>	<b>29606.0</b>	<b>22.3%</b>
Цэвэр хөрөнгө, өмч	781708.0	731168.5	-50539.5	-6.5%
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>914562.3</b>	<b>893628.8</b>	<b>-20933.4</b>	<b>-2.3%</b>

Авлага дансны үлдэгдэл 28585.9 мянган төгрөг болж 2498.1 мянган төгрөгөөр өссөн нь түрээслэгчтэй тооцоо нийлж түрээслэгчдээс авах дансны авлага 2498.1 мянган төгрөгийн авлага үүссэнийг бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 63665.6 мянган төгрөг болж 3553.3 мянган төгрөгөөр өссөн нь тайланд онд аж ахуйн материалын эцсийн үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 826252.5 мянган төгрөг, оны эцэст 800569.9 мянган төгрөг болж 25682.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн данс нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар паркийн шинэчлэлийн ажлын 13 нэр төрлийн 268912.5 мянган төгрөгийн тоглоомуудыг шинээр, 98862.0 мянган төгрөгийн хөрөнгийг өртөг нэмэгдүүлж, 212429.2 мянган төгрөгийн Бизнес инкубатор төвийг аймгийн ИТХ-ын 2020 оны 16 тоот тогтоолоор аймгийн ЗДТГ-ын балансад шилжүүлж, элэгдлийн зардал 11270.0 мянган төгрөг болсонтой холбоотой буурсан байна.

Өр төлбөр оны эхэнд 132854.3 мянган төгрөг ба үүний 35609.3 мянган төгрөг НӨАТ-ын, 9488.9 мянган төгрөг ХХОАТ-ын, 28648.7 мянган төгрөг нь НДШ-ийн, 9298.6 мянган төгрөгийн бусад татварын өглөг, 78288.6 мянган төгрөгийн халаалт дулааны өр төлбөр бүртгэсэн ба Ховд дулааны станц ТӨХК-тай тарифын маргаантай шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлэхээр нэхэмжлэл гаргасан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 731168.5 мянган төгрөг болсон байгаа нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

Мянган Угалзат ОНӨААТҮГ-ын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 242630.1 мянган төгрөгөөр буюу 121.7 хувиар өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын орлого нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 8439.2 мянган төгрөгөөр буюу 6.9 хувиар буурсан, өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт үйл ажиллагааны зардал буурсантай холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй байна.

### 3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Мянган Угалзат ОНӨААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, аймгийн ИТХ-аар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 4 дүгээр сарын 24-ны 92 дугаар тогтоолоор Мянган Угалзат ОНӨААТҮГ-ын 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогын доод хязгаарыг 263600.0 мянган төгрөгөөр, зарлагын дээд хязгаарыг 262793.4 мянган төгрөгөөр, цэвэр ашгийг 806.0 мянган төгрөгөөр тогтоосон байна. Үүнээс цалингийн санг 105429.7 мянган төгрөгөөр тус тус баталсан байна.

Гүйцэтгэлээр 147876.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 268912.6 мянган төгрөгийн үнэгүй орлого буюу хөрөнгө оруулалт орж, 267855.1 мянган төгрөгийн зардал гарган 18336.3 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Орлогын эх үүсвэр нь борлуулалтын орлого 147876.8 мянган төгрөг, 268912.6 мянган төгрөгөөр бусад орлогоос бүрджээ. Нийт орлогын 15 хувийг ахуй үйлчилгээний түрээсийн орлого, 42.2 хувийг Нэвт амралтын орлого, 42.8 хувийг Хүүхдийн паркийн үйл ажиллагааны орлого эзэлж байна. Хүснэгт 1. 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/Мян.төгрөг/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019 оны гүйцэтгэл	2020 оны		Зөрүү
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	<b>Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт</b>					
2	<b>Нийт орлого</b>	<b>мян.төг</b>	199334.3	263600.0	416789.4	153189.4
	Үүнээс: Цэвэр борлуулалт	мян.төг	199334.3	263600.0	147876.8	-115723.2
	Бсад орлого				268912,6	268912.6
3	<b>Нийт зардал</b>	<b>мян.төг</b>	278217.9	262793.4	398453.1	-135659.7
	Үүнээс:	мян.төг	49956.8	49956.8	25175.0	24781.8
	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг					
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	мян.төг	189515.1	212836.6	372278.1	-159441.5
	в) Хөрөнгө оруулалт их засвар					
4	<b>Цэвэр ашиг, алдагдал</b>	<b>мян.төг</b>	-78883.6	806.6	18336.3	17529.7

Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлтүүдийн биелэлт, гүйцэтгэлийн шалтгаан нөхцөлийг үзүүлэлт бүрээр танилцуулбал:

Нийт өөрийн орлогын гүйцэтгэл 115732.2 мянган төгрөгөөр биелээгүй нь Ковид-19-ын хөл хорио мөн 2012 онд ИТХ-аас тогтоосон паркийн тасалбарын үнэ тариф одоо болтол мөрдөгдөж байгаа, Нэвт амралтын ахмадын ор хоногийн төлбөрийг ХНХЯ-ны сайдын баталсан тарифаар мөрдөж ажилласантай холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 398453.1 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 135659.7 мянган төгрөгийн илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь өмнөх жилээс бараа материалын үнэ өссөн, мөн ИТХ-ын шийдвэрийн дагуу ЗДТГ-т конторын барилгыг төлбөргүй шилжүүлсэнтэй холбоотой үл хөдлөх хөрөнгө шилжүүлсний гарз хүлээн зөвшөөрсөнтэй холбоотой.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### 3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа

Төлөөлөн удирдах зөвлөл нь хуульд заасны дагуу аймгийн ИТХ-аас баталж томилсон 7 хүний бүрэлдэхүүнтэй буюу бүгд ИТХ-ын төлөөлөгч нар байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 2020 онд 2 удаа зохион байгуулж 5 асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

2020 онд ТУЗ-ийн үйл ажиллагааны зардалд хөрөнгө зарцуулаагүй байна.

### 3.8. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 146 мэдээллээс хугацаандаа оруулсан 103 мэдээлэл байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянахад санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, аудитын дүгнэлт зөвлөмжийн мөрөөр хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан, дараа жилийн төсвийн төсөл зэргийг мэдээлээгүй байна.

### 3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өглөг, бараа материал, орлогын төлөвлөгөөний талаар 3 зөвлөмж өгөгдсөнийг 50 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт /сая.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	0	1	0	0	0	50
Нийт дүн	1	0	1	0	0	0	50

### 3.10. Аудитын илрүүлэлт

Аудитаар өмнөх онд өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй төдийгүй авлага өглөг бууруулж ажиллах 1 зөвлөмж өглөө.

**Залруулсан алдаа:** Аудитаар залруулсан алдаа байхгүй болно.

**Аудитын зөвлөмж:** Аудитаар илэрсэн 1 алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Дараагийн аудитаар авч үзэх онц асуудал байхгүй гэж үзлээ.

## 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

## Авлага өглөгтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Тайлант онд өөрийн үйл ажиллагааны орлогыг төлөвлөгөөг 115723.1 мянган төгрөгөөр тасалсан төдийгүй, авлагыг 2498.1 мянган төгрөгөөр, өглөгийг 29606.0 мянган төгрөгөөр тус тус өсгөсөн, харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж тооцооны үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулаагүй байна.

Эрсдэл: Төсвийн зарцуулалтын хяналт сулрах, үйл ажиллагаа явуулах эх үүсвэр дутагдаж, байгууллагын хэвийн ажиллагаа алдагдах

1.2 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6.4.8. “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, гэсэн заалтыг мөрдөн ажиллаж, 2021 онд өр авлагыг бууруулах, харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж хэвших, өмнөх оны аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах.

1.3 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 5 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	<b>Мянган Угалзат ОНӨААТҮГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
2021			ХОА-2021/02/СТА-ОНӨААН
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Мянган Угалзат ОНӨААТҮГ</b>		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Авлага, өр төлбөрийг нэмэгдүүлсэн харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж тооцооны үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулаагүй байна.	32104.1	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Д.Отгонтуяа, Т.Цэвээнням
2	Өмнөх оны аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй.		Дүгнэлтэнд нөлөөлөх	Дарга, нягтлан бодогч	Д.Отгонтуяа, Т.Цэвээнням
<b>ДҮН</b>		32104.1			

## ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР